



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 01/95

Мандалговь

“Гранд холдинг” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хамтарсан хөрөнгө оруулалтаар санхүүжих “Инженерийн хийцтэй худаг гаргах” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Гранд холдинг” ХХК-тай 199,473,468 (Нэг зуун ерэн есөн сая дөрвөн зуун далан гурван мянга дөрвөн зуун жаран найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан стандарт, техникийн үзүүлэлтийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гранд холдинг” ХХК-ний захирал (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



4892150199